

БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Б.Нарантулга, Доктор (Ph.D), Дэд профессор, Улс төр судлал, нийгмийн удирдлагын тэнхим, Удирдлагын академи

Хураангуй

Өгүүлэлд боловсролын үйлчилгээг төрийн үйлчилгээ болох талаас нь онцолж, түүний хүртээмжийг тодорхойлох хэмжүүрүүдийг судлан үзэв. Улаанбаатар хот дахь төрийн үйлчилгээний хүртээмжийг тоймлон зураглаж, боловсролын үйлчилгээний хүртээмж, түүнд шилжих хөдөлгөөний үзүүлж буй нөлөөллийг ерөнхий боловсролын үйлчилгээний жишээн дээр тодруулсан болно.

Монгол улсын хүн амын шилжих хөдөлгөөнд хөдөөгөөс хот руу, тэр дундаа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал эрчимтэй явагдаж, ердөө 15 жилийн дотор тус хотод шилжин суурьшигчдын тоо 360 гаруй мянгад хүрчээ. Хүн амын энэхүү хурдацтай өсөлт нь нийслэлийн нийгэм, эдийн засагт төдийгүй төрийн үйлчилгээнд ихээхэн ачааллыг бий болгож байна. Шилжих хөдөлгөөний нөлөөгөөр ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо жилээс жилд өсөж байхад түүнтэй зэрэгцээд төрийн өмчийн сургууль барих ажил удаашралтай байгаа нь нэг сургуульд ногдох хүүхдийн тоо нэмэгдэж, сургуулийн хүртээмж буурах нөхцөл болж байна. Тухайлбал: 2015-2016 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын төрийн өмчийн 5 сургууль тутмын нэг нь 3 ээлжээр хичээллэж байна. Анги дүүргэлтийг 30-35 байхаар журамласан хэдий ч төрийн өмчийн 12 сургууль тутмын нэгд нь 40-өөс давсан байв. Улаанбаатар хотод шилжин ирэгчид гол төлөв гэр хороололд суурьшиж, гэр хорооллууд зах хязгаарын хувьд өргөжин тэлж байгаа нь боловсролын хүртээмжийг тодорхойлох нэг үзүүлэлт болох гэрээс сургууль хүртэлх зай холдоход нөлөөлжээ. Зарим эх сурвалжид гэрээс сургууль хүртлэх зай дунджаар 4.1 километр хүрсэн талаар дурьдсан нь нийслэлд ерөнхий боловсролын үйлчилгээ авахад бэрхшээлтэй нөхцөл байдал хэдийнэ үүссэнийг илтгэж байна.

Түлхүүр үгс: Хүн амын өсөлт, ээлжийн коэффициент, анги/бүлэг дүүргэлт, багш, сурагчийн харьцаа, сургууль хүртэлх зай.

Abstract

This article explores the education services specifics that represent public services and its indicators to define education access are studied. The impact of internal migration on access to public service is studied in case of education access in the Ulaanbaatar.

Mongolia has experienced continued rural-urban migration streams, particular to Ulaanbaatar. Due to the migration stream, number of in-migrants in the city increased by over 360 thousands during the last 15 years. The rapid growth of population in Ulaanbaatar, influences on economic and social burden, including access to public services. By reason of the migration, number of in-school children is increasing year by year. However, construction of new public schools, which should follow intensive growth of in-school children is inadequate in Ulaanbaatar. It has influence on overcrowded schools in the city and lack of education access. Totally, in Ulaanbaatar, 1/5 of public schools have 3 shifts for studying in 2015-2016 academic year. Although an estimated number of class size are 30-35, in actuality 1/12 of public schools have over 40 students studying in one classroom. As rural-urban migrants are moving to outskirts of city, distance to school, which is one of main indicator of education access, is becoming far from households in ger area. According to the some survey findings, average distance to school in ger areas is 4.1 kilometers. This long distance indicates difficult circumstance for access to education.

Key words: Population growth, shift coefficient, number of students in classroom/class size, teacher, student ratio, distance to school.

1. Удиртгал

Эдүгээ дэлхийн улс орнууд хүн төвт хөгжлийн үзэл баримтлалаар хөгжиж, хүний хөгжил, амьдралын чанарт гарч буй ололт, амжилтаар улс орныхоо хөгжил, дэвшлийг тодорхойлж байгаа билээ. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд Мянганы хөгжлийн зорилт (2015 он хүртэл), Тогтвортой хөгжлийн зорилт (2030 он хүртэл) зэрэг хүний хөгжлийн төлөөх бодлогын баримт бичгүүдийг баталж, улс орнууд эдгээртэй уялдуулан үндэсний түвшний бодлого⁷, хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Боловсрол нь хүний хөгжлийн тулгуур хүчин зүйлийн нэг төдийгүй хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин зэрэг бусад хэмжээст ч нөлөөлдөг үзүүлэлт болохын хувьд боловсролын салбарыг нийгмийн тэргүүлэх салбар хэмээн үзэж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд бодлогын түвшинд анхаардаг билээ. Хэрэглэгчдэд ойр, тэдний эрэлт хэрэгцээг хангахуйц, уян хатан, чанартай боловсролын үйлчилгээний үндсэн дээр хүмүүсийн боломж, чадавх дээшилж, сонголтын хүрээ өргөжих зүй тогтол бий.

2. Боловсролын үйлчилгээний хүртээмжийн талаарх ойлголт

Боловсролын үйлчилгээ нь иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний нийтлэг хэлбэр юм. Төрийн үйлчилгээ хэмээх ойлголтыг явцуу утгаар тодорхойлбол Засгийн газрын үйл ажиллагаа, харин өргөн утгаар нь авч үзвэл “*Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн зорилт, чиг үүргийг бүтээгдэхүүний хэлбэрээр болон үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжүүлж буй төрийн байгууллагын үйл ажиллагаа*” юм (В.Удвал, 2005, 19 дэх тал). Иймээс боловсролын үйлчилгээ гэдэг нь уг үйлчилгээг иргэдэд үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагууд, тодруулбал, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон их, дээд сургуулиар дамжин иргэдэд хүрч буй сургалт, төлөвшлийн олон талт үйл ажиллагаа юм.

Ийнхүү төрийн байгууллагууд иргэдэд үйлчилгээ хүргэх үүрэгтэй байдаг бол иргэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж зэрэг төрөөс үзүүлж буй үйлчилгээг хүртэх эрхтэй байдаг. Сургуульд сурах, нийтийн тээврээр зорчих, тэтгэвэр, тэтгэмж авах гээд өдөр тутмын амьдралдаа төрийн үйлчилгээнд хамрагддаггүй хүн нэгээхэн ч үгүй тул төрийн үйлчилгээг авах, эс авах нь сайн дурын хэрэг биш (W. Pieterse, 2009, p.14). Энэ утгаараа төрийн үйлчилгээ нь иргэдэд хэрхэн хүрч байгааг судлахдаа нэн түрүүнд хүртээмж, цаашилбал чанар, хэмнэлт, үр нөлөө зэрэг нийтлэг шалгуурыг ашиглана.

Төрийн үйлчилгээний үндсэн шалгуур болох хүртээмж гэсэн ойлголт нь хүн бүрт адил тэгш боломж бүрдүүлсэн эсэхээр тодорхойлогддог. Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд “*Боловсролын үйлчилгээний хүртээмж гэдэг нь бүх хүнд боловсрол эзэмших адил тэгш боломж бүрдүүлсэн нөхцөл байдал юм*” гэжээ (МУ-ын Засгийн газар, 2006). Үүнээс үзвэл, боловсролын үйлчилгээний хүртээмжийг сургууль, анги, танхим, багшлах боловсон хүчний хүрэлцээ, хангамж, сургууль хүртлэх зай зэрэг нийтлэг хэмжүүрээр судлан тодорхойлж болохоор байна. Харин боловсролын үйлчилгээг бүхэл бүтэн систем буюу тогтолцоо болох талаас нь авч үзвэл, уг үйлчилгээний хүртээмжийг орц, үйл явц, гарцыг харуулах олон хэмжээст үзүүлэлтээр судлах шаардлагатай.

Боловсролын үйлчилгээний хүртээмжид тухайн улсын болон орон нутгийн хүн амын тоо, өсөлт, эдийн засгийн нөөц боломж, үйлчилгээ үзүүлэгчдийн тоо, чадавхи, газар зүйн байршил зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Боловсрол эзэмших нь хүний үндсэн эрх болох утгаараа ч, төрийн аливаа үйлчилгээ иргэдэд тэгш, хүртээмжтэй хүрэх ёстой гэдэг утгаараа ч амьдарч буй газар, орлогын түвшин, нийгэмд эзэлж буй байр суурь зэргээс үл хамааран Монгол улсын иргэн бүрт боловсролын үйлчилгээ авах боломж эн тэнцүү олгогдох ёстой. Гэвч шилжих хөдөлгөөний нөлөөгөөр нийслэл Улаанбаатар хотын хүн ам ихээхэн өсөн

⁷ “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилт” (2005-2015 он), “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2007-2021 он), “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (2016-2030 он) зэрэг бодлогын баримт бичгүүдийг дурьдаж болно.

нэмэгдэж, энэ нь боловсролын үйлчилгээ, тэр дундаа ерөнхий боловсролын үйлчилгээний ачааллыг нэмэгдүүлж, хүртээмж буурахад нөлөө үзүүлж байна.

3. Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ба төрийн үйлчилгээний хүртээмж

Цэвэр шилжилт нь шилжих хөдөлгөөний нөлөөгөөр аливаа орон нутгийн хүн амын тоо хэмжээнд гарсан өөрчлөлтийг харуулдаг учир Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний төлөв байдлыг сүүлийн

15 жилийн динамик мэдээлэлд тулгуурлан цэвэр шилжих хөдөлгөөний үзүүлэлтээр судалж үзсэн болно (Хүснэгт 3.1).

Ингэхэд, манай улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд гол төлөв Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал ажиглагджээ. Өөрөөр хэлбэл 2000-2015 оны туршид шилжин ирэлт, шилжин явалтаас тогтмол өндөр буюу цэвэр шилжилт эерэг утгатай, бусад аймгуудтай харьцуулахад цэвэр шилжилтийн түвшин хамгийн өндөр байгаа цорын ганц орон нутаг бол Улаанбаатар хот байв.

Хүснэгт 3.1: Хүн амын цэвэр шилжилт, аймаг/нийслэл болон бүсээр, 2000-2015 он

Бүс, аймаг/нийслэл	2000-2004	2005-2009	2010-2015	2000-2015
Баруун	-52547	-39191	-39380	-131118
Баян-Өлгий	-2545	-8464	-6062	-17071
Говь-Алтай	-7973	-6074	-7458	-21505
Завхан	-17462	-6441	-10375	-34278
Увс	-16786	-11277	-8476	-36539
Ховд	-7781	-6935	-7009	-21725
Хангайн	-39106	-29336	-42445	-110887
Архангай	-10643	-9204	-8669	-28516
Баянхонгор	-9168	-4407	-6672	-20247
Булган	-5923	-2446	-2936	-11305
Орхон	3420	-1743	-4887	-3210
Өвөрхангай	-9697	-4699	-11718	-26114
Хөвсгөл	-7095	-6837	-7563	-21495
Төвийн	-38153	-20857	-14795	-73805
Говьсүмбэр	-1031	717	770	456
Дархан-Уул	225	-3957	-4181	-7913
Дорноговь	-1968	1270	-90	-788
Дундговь	-6117	-6196	-5752	-18065
Өмнөговь	-3708	-1364	2538	-2534
Сэлэнгэ	-6679	-4409	-2269	-13357
Төв	-18875	-6918	-5811	-31604
Зүүн	-17245	-16717	-12080	-46042
Дорнод	-7142	-6409	-5098	-18649
Сүхбаатар	-4591	-5469	-2336	-12396
Хэнтий	-5512	-4839	-4646	-14997
Улаанбаатарын	133429	112996	115289	361714
Улаанбаатар	133429	112996	115289	361714
Цэвэр шилжилт эерэг утгатай аймаг, хотууд (буурах эрэмбээр)	УБ Орхон Дархан-Уул	УБ Дорноговь Говьсүмбэр	УБ Өмнөговь Говьсүмбэр	УБ Говьсүмбэр

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Хүн амын ердийн хөдөлгөөний хагас, бүтэн жилийн тайланд үндэслэсэн судлаачийн тооцоо (<http://www.1212.mn>)

Хүснэгтээс харахад баруун, хангайн, төвийн болон зүүн бүсийн аймгууд бүхэлдээ шилжигчдийг илгээгч, Улаанбаатарын бүс, тэр дундаа төвийн дүүргүүд шилжигчдийг хүлээн авагч бүс болсон нь тодорхой байна. Учир нь тус хотын нийт хүн амын 95 хувийг төвийн 6 дүүргийн хүн ам бүрдүүлж байгаа билээ.

Мөн хугацаанд Улаанбаатар хотын нэг өдрийн цэвэр шилжилт 70 орчим хүнээр, нэг жилийн цэвэр шилжилт 24-25 мянган хүнээр тус тус тоологдож байгаа нь шилжих хөдөлгөөн тус хотын хүн амын өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулсаныг харуулж байна. Эндээс Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд хөдөөгөөс хот руу, тэр дундаа нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал ажиглагдаж, энэ нь тус хотын хүн амын өсөлт, хэт төвлөрлийн үндэс болж байгаа нь тодорхой байна.

2015 оны эцсийн байдлаар Монгол Улсын суурин хүн ам 3057778, үүнээс Улаанбаатар хотын хүн ам 1396288 байгаагаас (ҮСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан) нийт хүн амын 45.7 хувь нь дангаараа Улаанбаатар хотын оршин суугч байгааг харж болно. Гэвч бүртгэлтгүй шилжин суурьшигчид, оюутнууд, түр оршин суугчдыг оролцуулбал тус хотын хүн ам магадгүй 1.5 саяд хүрнэ. Жишээ нь: 2010 оны 3 дугаар сард Нийслэлийн захирагчийн ажлын албанаас хийсэн иргэний бүртгэлийн шалгалтаар 21217 хүн (ХАХНХЯ, 2013, 24 дэх тал) шилжих хөдөлгөөний бүртгэлээ хийлгээгүй зөрчил илэрсэн нь тус хотод бүртгэлгүй шилжин суурьшигчид багагүй хувь хэмжээтэй байгааг харуулж байгаа юм.


Улаанбаатар хотын хүн амын өсөлт, хэт төвлөрөл нь тус хотын засаг захиргааны болон бусад байгууллагуудын ачааллыг нэмэгдүүлсэн ба нийслэлийн нэг хороог бусад аймгуудын нэг багтай харьцуулахад даруй 7-11 дахин олон иргэнд үйлчлэх хэрэгцээ гарч байгаа нь дараахь зургаас тодорхой байна.

Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний төлөв байдлаас харахад Баруун, Хангайн, Төвийн болон Зүүн бүсийн аймгууд бүхэлдээ шилжигчдийг илгээгч, Улаанбаатарын бүс, тэр дундаа төвийн дүүргүүд шилжигчдийг хүлээн авагч бүс болсон нь тодорхой байна. Учир нь тус хотын нийт хүн амын 95 хувийг төвийн 6 дүүргийн хүн ам бүрдүүлж байгаа билээ. Мөн хугацаанд Улаанбаатар хотын нэг өдрийн цэвэр шилжилт 70 орчим хүнээр, нэг жилийн цэвэр шилжилт 24-25 мянган хүнээр тус тус тоологдож байгаа нь шилжих хөдөлгөөн тус хотын хүн амын өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулсныг харуулж байна. Эндээс Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд хөдөөгөөс хот руу, тэр дундаа нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал ажиглагдаж, энэ нь тус хотын хүн амын өсөлт, хэт төвлөрлийн үндэс болж байгаа нь тодорхой байна.

2015 оны эцсийн байдлаар Монгол Улсын суурин хүн ам 3057778, үүнээс Улаанбаатар хотын хүн ам 1396288 байгаагаас (ҮСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан) нийт хүн амын 45.7 хувь нь дангаараа Улаанбаатар хотын оршин суугч байгааг харж болно. Гэвч бүртгэлтгүй шилжин суурьшигчид, оюутнууд, түр оршин суугчдыг оролцуулбал нийслэлийн хүн ам магадгүй 1.5 саяд хүрнэ. Жишээ нь: 2010 оны 3 дугаар сард Нийслэлийн захирагчийн ажлын албанаас хийсэн иргэний бүртгэлийн шалгалтаар 21217 хүн (ХАХНХЯ, 2013, 24 дэх тал) шилжих хөдөлгөөний бүртгэлээ хийлгээгүй зөрчил илэрсэн нь тус хотод бүртгэлгүй шилжин суурьшигчид багагүй хувь хэмжээтэй байгааг харуулж байгаа юм.

Улаанбаатар хотын хүн амын өсөлт, хэт төвлөрөл нь тус хотын засаг захиргааны болон бусад байгууллагуудын ачааллыг нэмэгдүүлсэн ба нийслэлийн нэг хороог бусад аймгуудын нэг багтай харьцуулахад даруй 7-11 дахин олон иргэнд үйлчлэх хэрэгцээ гарч байгаа нь дараахь Зураг 1-ээс тодорхой харагдаж байна.

Зураг 3.1: Нэг баг, хороонд ногдох хүн амын тоо, бүсээр, 2015 он



Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл 2014, ҮСХ, УБ., 2015, 13 дахь тал; Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn-д суурилсан судлаачийн тооцоо

Энэхүү нөхцөл байдалд хөдөөгийн таруу байршил, сийрэг суурьшил, аймаг, сумын төвөөс алслагдсан байдлыг харгалзах нь зүйн хэрэг боловч Улаанбаатар хотод өрхийн эмнэлгээс эхлээд сургууль, цэцэрлэг, нийтийн тээвэр зэрэг үйлчилгээний ачаалал ихсэж, хүртээмж хязгаарлагдаж байгаа нь үүгээр харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын хэмжээнд төрийн өмчийн цэцэрлэгийн нэг ангид 50-аас олон хүүхэд ногддог, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахын тулд урт дараалал хүлээдэг зэрэг нийтлэг дүр зураг нь чухамдаа хүн амын хэт төвлөрлөөс улбаатай байна. Иймээс хүн амын хэт төвлөрлөөс үүдэн төрийн үйлчилгээний хүртээмж буурах явдлыг зохицуулах зорилгоор Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр зөвхөн 2011 оноос хойш 20 хороог шинээр байгуулж, Улаанбаатар хотын хэмжээнд нийтдээ 152 хороотой болсон байна.

Манай улсад төрийн үйлчилгээг үндэсний, аймаг/нийслэлийн, сум/дүүргийн болон баг/хорооны гэсэн үндсэн 4 түвшинд үзүүлж байгаа учир засаг захиргааны анхан шатны нэгжүүд дэх хүн амын харьцангуй жигд тархалтыг хангаснаар үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой. Гэвч Улаанбаатар хотын нэг хорооны хүн амын тоо харилцан адилгүй тархалттай⁸ байна. Өнөөдөр тус хотын нийт хороодын түвшинд өрхийн эмнэлэг, цагдаа,

иргэний бүртгэл, нийгмийн даатгал, халамж, хөдөлмөр эрхлэлт зэрэг төрийн үйлчилгээг нэг дороос, чирэгдэл багатай авах нөхцөл бүрдсэн. Харин шинэ хороо, хороолол болгонд цэцэрлэг, сургууль барих ажил тийм ч ахицтай биш байгаа нь боловсролын үйлчилгээний хүртээмж, улмаар чанарт сөргөөр нөлөөлж байна.

4. Улаанбаатар хотын хүн амын боловсролын үйлчилгээний хүртээмж дэх шилжих хөдөлгөөний нөлөөлөл

2015-2016⁹ оны хичээлийн жилд Монгол улсын хэмжээнд ерөнхий боловсролын 776 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр сургуулиудад нийтдээ 534.8 мянган хүүхэд суралцаж байв (БСШУЯ, 2015). Ерөнхий боловсролын сургуулиудын 27.5 хувь нь Улаанбаатар хотод байршиж, нийт нийт суралцагчдын 41.3 хувь нь энд суралцаж байна. Мөн Улаанбаатар тус хотын нэг сургууль улсын дундаж болон бусад бүсээс 300-400-аар олон тооны сурагчтай бөгөөд, нэг багш даруй 6-9-ээр илүү тооны хүүхэдтэй ажиллах хэрэгцээ, шаардлага гарч байгаа ажээ (ҮСХ, 2015, 90-92 дахь тал). Нэг сургуульд ногдох суралцагчийн тоо, сурагч багшийн харьцаа зэрэг үзүүлэлтээс харахад, Улаанбаатар хотын сургуулиуд хүчин чадал, багтаамжаасаа илүү олон тооны суралцагчдыг “шингээж”, улмаар сургуулиудын ачаалал ихээхэн нэмэгдсэн нь

⁸ Улаанбааттар хотын хэмжээнд нийт 152 хороо байгаа бөгөөд нэг хороонд 641-18834 хүн ногдож байна.
⁹ 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээлэл бүрэн олдоогүй учир өмнөх хичээлийн жилийн мэдээлэлд тулгуурлан тайлбар, шинжилгээ хийв.

тодорхой байна. Сонгинохайрхан дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн ЕБС-ууд нийтдээ 16 мянга сурагчийн багтаамжтай боловч 33 мянган сурагч суралцаж байгаа (ҮСГ, НҮБХАС, 2007, 64 дэх тал) гэх мэдээлэл ч үүнийг баталгаажуулав.

Нийслэл хотын ерөнхий боловсролын үйлчилгээний ачааллыг хувийн сургуулиуд тодорхой хэмжээгээр хуваалцаж байгаа боловч сургалтын төлбөр өндөр учраас үйлчлэх хүрээ хязгаарлагдмал, гол төлөв дундаас дээгүүр болон өндөр орлоготой өрхийн хүүхдүүд ийм төрлийн сургуульд суралцаж байна. 2000-2001 оны хичээлийн жилтэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй сургуулиудын тоо 146-210 болж нэмэгдэхэд хувийн хэвшлийн сургуулиудын өсөлт гол нөлөөг үзүүлсэн¹⁰. Гэвч өнөөдөр нийт сурагчдын 10.6 хувь нь (ҮСХ, 2015, 91 дэх тал) Улаанбаатар хотын төрийн бус өмчийн буюу хувийн ЕБС-д суралцаж байна. Эндээс, нийгмийн суурь үйлчилгээ болох боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй 10 хүн тутмын 9 нь төрөөс үзүүлж буй үнэ төлбөргүй боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, ЕБС-ийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд нийслэлд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн сургуулиуд гол үүрэг гүйцэтгэж байна.

ЕБС-ийн хүртээмжийг илэрхийлэх чухал үзүүлэлтийн нэг нь ээлжийн коэффициент байдаг. Социализмын үед манай улсын ихэнх сургуулиуд 320 хүүхдийн хүчин чадалтай баригдаж, 640 хүртлэх хүүхэд суралцаж ирсэн, нөгөө талаас халаалт, цахилгаан зэрэг урсгал зардал, төсөв санхүүгийн хэмнэлтийн талаас 2 ээлжээр хичээллэхийг үндсэндээ хэвийн зүйл гэж ойлгодог. Гэвч сурагчдын хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд хамрагдах байдлын хувьд ээлжийн үзүүлэлтийг 1.5-аас хэтрүүлэхгүй байлгахад анхаарах шаардлага бий. 2015-2016 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын хэмжээнд төрийн өмчийн ихэнх сургууль 2 ээлжээр, 23 сургуулийн 174 бүлгийн 6278 сурагч 3 ээлжээр хичээллэсэн байна (НБГ,

2016, 54 дэх тал). Энэ нь нийслэлийн төрийн өмчийн 5 сургууль тутмын нэг нь өглөө, өдөр, оройн ээлжээр хичээллэж байгааг харуулж байгаа юм. 2004-2005 оны хичээлийн жилд 162 бүлгийн 5700 орчим хүүхэд 3 ээлжээр хичээллэж байсан (Ц. Баярсайхан, 2005, 56 дахь тал), мөн 2016-2017 оны хичээлийн жилд нийт 34 сургуулийн 9923 хүүхэд 3 ээлжээр хичээллэж байгаа (УИХ-ын хэвлэл, мэдээллийн алба, 2016) зэргээс харахад 3 ээлжээр хичээллэх сургуулиудын тоо жилээс жилд олширсоор байна.

Одоогоор Улаанбаатар хотын хэмжээнд төрийн өмчийн ихэнх сургууль 2 ээлжээр, 23 сургуулийн 174 бүлгийн 6278 сурагч 3 ээлжээр хичээллэж байна (НБГ, 2016, 54 дэх тал). Энэ нь нийслэлийн төрийн өмчийн 5 сургууль тутмын нэг нь өглөө, өдөр, оройн ээлжээр хичээллэж байгааг харуулж байгаа юм. 2004-2005 оны хичээлийн жилд 162 бүлгийн 5700 орчим хүүхэд 3 ээлжээр хичээллэж байсан (Ц. Баярсайхан, 2005, 56 дахь тал)-аас харахад 3 ээлжээр хичээллэх сургуулиудын тоо жилээс жилд олширсоор байна.


Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнөөс хамааран цагийн ачаалал харьцангуй багатай бага анги буюу зөвхөн 1-5 дугаар ангийн сурагчид 3 ээлжээр байгаа нь бас л анхаарал татсан дүр зураг юм. Энгийн жишээ дурьдахад, эрүүл мэндийн талаас 'оройн хоолыг 7 цагаас өмнө идэж хэвших нь зүйтэй' гэж зөвлөдөг хэдий ч үндсэндээ оройн 7 цагт хичээл нь тарж байгаа сурагчид энэ дэглэмийг мөрдөх боломжгүйд хүрч байна. Түүнчлэн 3 ээлжээр хичээллэж буй сургуулиудын 1-2 дугаар ээлжийн хичээл тарах, 2-3 дугаар ээлжийн хичээл орох хоорондох хугацаа маш бага байдаг учир анги, танхимын ариун цэвэр, эрүүл ахуй, сурагчдын эрүүл мэндийн хувьд бэрхшээлтэй байдлыг бий болгож байгааг дурьдах нь зүйтэй.

Ээлжийн үзүүлэлтээс гадна нэг ангид ногдох сурагчийн тоо нь сургалтын үйл ажиллагаа хүүхэд нэг бүрт хэрхэн хүрч байгааг илэрхийлэх хүртээмжийн чухал хэмжүүр

¹⁰ 2014-2015 оны хичээлийн жилд Улаанбаатар хотод төрийн бус өмчийн нийт 94 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Үүний нөгөө талд төрийн өмчийн ЕБС-уудын тоо буурсан мэт харагдаж байгаа нь тодорхой тооны сургуулиудыг нэгтгэж, үйл ажиллагааг нь цогцолбор хэлбэрээр зохион байгуулсантай холбоотой.

болдог. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалаар “Анги дүүргэлтийг ердийн сургалттай сургуулийн бага ангид 30-35 (багын салбар бүлэгт 20-оос доошгүй), дунд, ахлах ангид 32-35 байхаар зохион байгуулах”-аар журамлаж, нэг ангид ногдох сурагчдын тооны стандартыг тогтоосон байдаг. 2015-2016 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын дунджаар бүлэг дүүргэлт 30.8 буюу дурьдсан стандартад нийцэж байгаа мэт харагдаж байгаа хэдий ч энэ нь төрийн болон төрийн бус өмчийн сургууль, бага, дунд, ахлах анги, дүүргүүдээр харилцан адилгүйн дээр (Зураг 4.1) аймаг, сумын төв, хөдөөгийн багтай харьцуулахад нэлээд өндөр үзүүлэлт болж байна.

Зураг 4.1: Төрийн өмчийн сургуулийн бүлэг дүүргэлт, 2015-2016 оны хичээлийн жилээр



Эх сурвалж: Нийслэлийн боловсролын газар, Боловсролын салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл (2015-2016 оны хичээлийн жил), УБ., 2016, 53, 57-64 дэх талд суурилсан судлаачийн нэгтгэл

Сургуулийн өмчийн хэлбэрээр бүлэг дүүргэлтийн үзүүлэлтийг авч үзвэл, Улаанбаатар хотын төрийн өмчийн сургуулийн нэг анги дунджаар 33.5, хувийн хэвшлийн сургуулийн нэг анги дунджаар 18.5 хүүхэдтэйгээр тус тус хичээл, сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс, улсын сургуулийн нэг ангид хувийн хэвшлийн бараг хоёр ангийг нийлүүлсэнтэй адил тооны хүүхэд суралцаж байгаа нь харагдлаа. Үүний цаана багшийн ачаалал нэмэгдэж, сурагч нэг бүртэй ажиллах боломж багасах, нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ буурснаар тоосжилт үүсэх, амьсгалын замын өвчлөлийн тархалт нэмэгдэх зэрэг эрсдэл бий.

Суралцагчдын нас, бие даан ажиллах чадвар зэргээс хамааран бүлэг дүүргэлтийн түвшинг дунд, ахлах ангиудад бага ангиас бага зэрэг илүү байхаар журамласан. Дээрх зургаас харахад, суралцаж буй анги болон бүлэг дүүргэлтийн түвшингийн хооронд урвуу хамаарал ажиглагджээ. Түүнчлэн сүүлийн жилүүдэд төрөлтийн түвшин нэмэгдэж байгаатай холбоотойгоор бүлэг дүүргэлт бага ангид нормативаас бага зэрэг хэтрэлттэй байв. Цаашид ч нэгдүгээр ангид элсэгчдийн

тоо тогтмол өндөр байх учир сургууль, анги танхим, багшийн хүрэлцээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Нийслэл дэх боловсролын үйлчилгээний хүртээмжийг аймаг, сум, багийн төвтэй харьцуулахын тулд дундаж хүн амтай аймаг болох Баянхонгор аймгийг кейс болгон сонгож авав. Баянхонгор аймгийн тухайд бүлэг дүүргэлтийн түвшин аймгийн дунджаар 26.2 бөгөөд энэ нь аймаг, сумын төв, хөдөөгийн багийн сургуулиудад ялгаатай¹¹ байна (Баянхонгор аймгийн БХ, 2015, 12 дахь тал). Эндээс аймаг, сум, багийн төвийн сургуультай харьцуулахад Улаанбаатар хот дахь төрийн өмчийн сургуулийн анги дүүргэлтийн үзүүлэлт 4-24 хүүхдээр давсныг харж болно.

Ихэнх аймгийн нөхцөл байдал уг аймагтай ойролцоо гэж үзвэл манай улсын аймгийн нийт сургууль, нэн ялангуяа, хөдөөгийн сургуулиудад нэг ангид суралцах хүүхдийн тоо 30-35 гэсэн нормативт хэмжээнд хүрэхгүй байгаа нь харагдаж байна. Иймээс аймаг, сумдын сургуулиудад анги дүүргэлтийн урьдчилсан тооцоо хийх, сургуулийн удирдлагын түвшинд элсэлт, төгсөлт, шилжилтийн статистик мэдээллийн хэрэглээг

нэмэгдүүлэх, төсвийн төсөл боловсруулахдаа тооцоо, судалгаанд тулгуурлах, ингэснээр санхүүгийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна.

2000-2001 оны хичээлийн жилтэй харьцуулахад 2015-2016 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ЕБС-д суралцагчдын тоо 494.6-534.8 мянга болж, 8.1 хувиар өссөн байхад Улаанбаатар хотын ЕБС-д суралцагчдын тоо 162.5-221.3 мянга болж 36.2 хувиар өссөн нь шилжих хөдөлгөөний шууд үр дагавар юм. Улаанбаатар хотыг зорих шилжигчид гол төлөв хотын төвийн дүүргүүдэд шилжин суурьшдаг учир эдгээр сургуулиудын нэг ангид ногдох сурагчийн тоо Налайх, Багануур, Багахангай гэсэн захын дүүргүүдтэй харьцуулахад өндөр байгааг Зураг 2-оос харж болно. 2015-2016 оны хичээлийн жилд анги дүүргэлт норматив хэмжээнээс хэтэрсэн буюу 40-өөс дээш байгаа 1, 23, 52, 111 зэрэг 10 сургууль бүртгэгдсэн нь нийслэлд үйл ажиллагаа явуулж буй нийт сургуулиудын 1/12-ийг эзлэх дүн юм.

Шилжигчид орлогын түвшин, эдийн засгийн боломжоосоо хамааран орон сууц худалдан авах чадвар хязгаарлагдмал учир гол төлөв гэр хороололд суурьшиж байна. Зарим эх сурвалж дахь Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн 80 хувь нь гэр сууцанд амьдардаг (ХАХНХЯ, НҮБХАС, 2013, 92 дахь тал) гэсэн тооцооноос шилжин сууршигчдын 80-аас илүү хувь нь гэр хороололд суурьшиж байгаа нь тодорхой байна. “Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар” судалгаанд Улаанбаатар хотын гэр хорооллын ЕБС-уудын анги дүүргэлт 40-53 байгаа талаар дурьдсан нь ч дээрх мэдээлэлтэй уялдаж байгаа юм.

Аливаа орон нутаг дахь хүн амын тооны өсөлтийг үйлчилгээ үзүүлэх байгууллагын тоо, хүчин чадлын өсөлттэй уялдуулж чадвал төрийн үйлчилгээний хүртээмж, тэгш байдлын зарчим хангагддаг. Гэвч Улаанбаатар хотын хүн амын өсөлтийг боловсролын үйлчилгээ үзүүлэх байгууллага, тэр дундаа төрийн өмчийн ЕБС-уудын өсөлт гүйцэж чадахгүй, нэг үгээр хэлбэл шинэ сургууль барих,

сургуулиудын барилгыг өргөтгөж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх ажил удаашралтай байгаа нь боловсролын үйлчилгээний хүртээмж хязгаарлагдахад хүргэж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар нийслэлийн хэмжээнд 3, 11 дүгээр дунд сургуулийн барилгыг шинээр барьсан бөгөөд одоогоор 32, 38, 73, 14 дүгээр сургуулиудын барилгын ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэл буюу концессийн гэрээгээр гүйцэтгэж байгаагаас өөр томоохон хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

Үүнтэй холбоотойгоор нэг сургуулийн хамран сургах тойргийн хүрээ тэлж, ачаалал нэмэгдэх нөхцөл болж байна. Жишээ нь: Хотын төвийн, хоттой ойр, хотын захын гурван гэр хорооллыг сонгон судлахад, зэргэлдээ орших дунд сургуульгүй хорооноос 1800-2700 орчим хүүхэд суралцаж байгаа ажээ (Дэлхийн банк, 2010, 73 дахь тал). Иймээс Улаанбаатар хотод шилжин ирж буй бүх хүүхдүүдийг ерөнхий боловсролын сургуульд бүрэн хамруулж, анги дүүргэлт, ээлжийн үзүүлэлтийг стандартын хүрээнд мөрдөн хүүхэд бүрийн сурч боловсрох эрхийг хамгаалахын тулд жилд дунджаар 320 хүүхдийн багтаамжтай 4-5 сургууль шинээр барих хэрэгцээ шаардлага тавигдаж байгаа (Б.Баатарзориг, 2005, 76 дахь тал) талаар тооцоо судалгаа ч бий. МУ-ын Засгийн газраас 2017 онд Улаанбаатар хотод 29 сургуулийн барилгыг концессийн гэрээгээр бариулах, шаардлагатай хөрөнгийн асуудлыг 2018 оны төсөвт тусгах шийдвэр гаргасан (УИХ-ын хэвлэл, мэдээллийн алба, 2016) нь чухал бодлогын санаачлага юм.

Боловсролын үйлчилгээний хүртээмжийн талаас хамгийн ойрхон сургууль хүртлэх зай 2 км байхаар бодож хот төлөвлөлт, барилгажилтын ажлыг зохион байгуулдаг. Мөн хүүхдүүд нь гэртэйгээ ойр сургуульд сурч байгаа эсэх нь өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлоход чухал үзүүлэлт болдог учир орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалд уг үзүүлэлтийг багтаасан байдаг.

Шилжих хөдөлгөөний нөлөөгөөр гэр хороолол зах хязгаарын хувьд тодорхой төлөвлөлт, зохион байгуулалтгүйгээр

¹¹ Бүлэг дүүргэлтийн дундаж түвшин Баянхонгор аймгийн төвийн сургуульд 29.2, сумын төвийн сургуульд 23.6, багийн төвийн сургуульд 6.7 байна.

өргөжин тэлж, нийслэлийн суурьшлын бүсийн 59.2 (Г. Нарангэрэл, 2012, 1 дэх тал) хувийг эзлэх болсноор Улаанбаатар хотод шилжин суурьшсан өрхүүд хамгийн ойрхон орших ЕБС-аас дунджаар 4.1 км-т алслагджээ. (НХХЯ, ХАССТ, 2009, 121 дэх тал) Ингэснээр боловсролын үйлчилгээний хүртээмж хязгаарлагдаад зогсохгүй сурагчид 2-3 автобус дамжиж сургуульдаа очих, нийтийн тээврийн үйлчилгээ хүртээмжгүй газруудад хувийн машинтай иргэдийн үзүүлж буй такси үйлчилгээнд хамрагдах зэргээр өрхийн санхүүгийн зардал нэмэгдэж, амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна. Одоогоор төрийн өмчийн сургуулиудын сурагчдад нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх механизм бүрдээгүй учир 5 хүүхэд тутмын 3 нь боловсролын үйлчилгээ авахын тулд явган алхаж сургуульдаа очдог (Дэлхийн банк, 2010, 73 дахь тал) явдал нь сурагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын талаас эрсдэл учруулж байгааг ч анзааралгүй орхиж боломгүй.

5. Дүгнэлт

Монгол Улс Үндсэн хуулиндаа Монгол Улсын иргэн сурч боловсрох эрхтэй бөгөөд төрөөс бүх нийтийн боловсролыг үнэ төлбөргүй олгоно хэмээн заасан байдаг. Ийнхүү иргэдийн сурч боловсрох үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэхийн тулд боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг сайжруулах бодлого, хөтөлбөр, тэдгээртэй нийцүүлэн холбогдох заавар, журам, стандартуудыг боловсруулан хэрэгжүүлж байна.

2000 оноос хойшхи 15 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөний нөлөөгөөр Улаанбаатар хотын хүн ам жилд 20 гаруй мянгаар нэмэгдсэн нь ЕБС-д суралцагчдын тооны өсөлтийг бий болгож, төрөөс үзүүлж буй нийт үйлчилгээ, түүн дотроо ерөнхий боловсролын үйлчилгээний хүртээмж буурахад ихээхэн нөлөөлөл үзүүлсэн. Өнөөдөр Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 5 сургууль тутмын нэг нь 3 ээлжээр хичээллэж байгаагаас гадна ийм төрлийн сургуулийн нэг ангид аймаг, сум, баг болон хувийн хэвшлийн ЕБС-тай харьцуулахад 4-24-өөр олон хүүхэд суралцаж, боловсролын үйлчилгээ авч байна.

Улаанбаатарт шилжин суурьшигчдын дийлэнх нь гэр хороололд төвлөрдгийн зэрэгцээ нийт суралцагчдын 90 орчим хувь нь төрийн өмчийн дунд сургуульд хамрагддаг учраас гэр хороололд үйл ажиллагаа явуулж буй, төрийн өмчийн ЕБС-уудад боловсролын үйлчилгээний хүртээмж, цаашлаад сургалтын чанар, сурагчдын хөгжлийн асуудал ихээхэн анхаарал татаж байна. Үүнд: Гэр хорооллууд зах хязгаарын хувьд өргөжин тэлснээр сургуулиас хамгийн ойрхон ЕБС хүртлэх зай 4.1 километрээр алсгагдаж, нэг сургуулийн ачаалал дунджаар 2000 орчим сурагчаар нэмэгдсэн зэрэг мэдээллүүдийг дурьдаж болно.

Ийнхүү нийслэл Улаанбаатар хотод боловсролын үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа явдал нь эл үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, улмаар боловсрол эзэмших эрхийг хангах бодлогын зорилт төдийлөн амжилттай хэрэгжихгүй байгааг харуулж байна. Цаашид боловсрол, тэр дундаа бага, дунд, суурь боловсролыг хүний хөгжил, амьдралын чанарын тулгуур хүчин зүйл хэмээн үзэж, нийслэлийн хүн амын боловсролын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах асуудалд онцгой анхаарах шаардлага байгаа нь өгүүлэлд дурьдагдсан тоон болон чанарын мэдээллээс тодорхой байна.

Үүний тулд, нэн тэргүүнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй боловсролын үйлчилгээ үзүүлэх төрийн өмчийн байгууллагын тоо хэмжээ, байршил, хүчин чадлыг дүүрэг, хороодын хүнамын тоо хэмжээ, өсөлт, байршилтай уялдуулан төлөвлөж, хэрэгцээний зураглал гаргах шаадлага бий. Улмаар шинээр ЕБС-ийн барилга барих, одоо байгаа сургуулиудын хүчин чадлыг нь өргөтгөн сайжруулах чиглэлд гаргасан бодлогын санаачлагыг ажил хэрэг болгоход төрийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээс гадна олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, цаашилбал төр-хувийн хэвшлийн түншлэлийг идэвхижүүлэх хөшүүрэг, урамшууллын механизм хэрэгтэй байна.

Ашигласан материал

- Ш. Батсүх, Я. Долгоржав, Б. Ганцоож, (2015). Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах нь судалгааны тайлан, Удирдлагын академи, Конрад Аденауэрэрийн сан, Улаанбаатар
- Ц. Баярсайхан, (2005). Шилжих хөдөлгөөнөөс нийгмийн салбарт гарч буй хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх бодлогын чиглэл илтгэл, Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх Үндэсний дээд хэмжээний уулзалт, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо, Хүн ам хөгжлийн асуудлаарх Азийн парламентчдын форум, НҮБХАС, Улаанбаатар
- Б. Баатарзориг, (2005). Шилжих хөдөлгөөн ба нийслэл хот илтгэл, Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх Үндэсний дээд хэмжээний уулзалт, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороо, Хүн ам хөгжлийн асуудлаарх Азийн парламентчдын форум, НҮБХАС, Улаанбаатар
- Нийслэлийн боловсролын газар (2016). Боловсролын салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл (2014-2015 оны хичээлийн жил), Улаанбаатар
- Боловсролын хэлтэс, (2016). Боловсролын салбарын 2014-2015 оны хичээлийн жилийн статистик мэдээллийн эмхэтгэл, Баянхонгор аймаг
- ХАХНХ Яам, АХБ, ХАССТ (2013). Нргэний бүртгэлийн тогтолцоог урамшууллын хэлбэрээр дэмжих нь судалгааны тайлан, Улаанбаатар
- МУ-ын Засгийн газар, (2005). Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Улаанбаатар
- Үндэсний статистикийн хороо (2015.) Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2014, Улаанбаатар
- МУ-ын Засгийн газар НҮБХХ (2011). Монголын хүний хөгжлийн илтгэл 2011. Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: Байгаль орчин, хүний хөгжил, Улаанбаатар
- ҮСГ, НҮБХАС (2007). Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чанарын судалгааны тайлан, Улаанбаатар НХХЯ, ХАССТ, НҮБХАС (2009). Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар судалгааны тайлан, Улаанбаатар
- ХАХНХЯ, НҮБХАС, (2013). Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, нийгмийн бодлого дахь хүн ам зүйн өөрчлөлтийн нөлөөлөл, Улаанбаатар
- Б. Нарантулга, Ч. Баатар, (2010). Орон нутгийн хөгжил: Бодлогын суурь үзэл баримтлал, НҮБХС, Улаанбаатар
- Г. Нарангэрэл, Хүн амын шилжих хөдөлгөөнийг зохицуулахгүй бол хот гамшгийн хэмжээнд очно нийтлэл, www.barilga.mn/news/r/67790үзсэн.2014.12.08
- Шинжлэх ухааны академи, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, (2009). Нийслэлийн хөгжил-шинжлэх ухаан, технологи Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, Улаанбаатар
- Нийслэлийн статистикийн газар, (2014). Нийслэлийн хөгжилд Улаанбаатар хотын эзлэх байр суурь, Улаанбаатар
- Сонгинохайрхан дүүрэг, (2009). Сонгинохайрхан дүүрэгт Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар
- ҮСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn
- В. Удвал (2005) (эмх). Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын хандлага. Онол, практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, судалгааны дүн, зөвлөмж, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи, Улаанбаатар
- Дэлхийн банк, (2010). Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх бодлого, арга барилыг сайжруулах нь Улаанбаатар
- UNDP, NY, (2011). Human Development Report 2011. Sustainability and Equity: A Better Future for All, USA,
- W.C. Pieteron, (2009). Citizens channel behavior and Public service channel strategy, dissertation